



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 11 нэрийн, нийт 62,777,391.96 (жаран хоёр сая долоон зуун далан долоон мянга гурван зуун ерэн нэгэн төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 12,734,993.99 (арван хоёр сая долоон зуун гучин дөрвөн мянга есөн зуун ерэн гурван төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг хүлээлцэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 05 дугаар сарын-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



"Дулаан шарын гол" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа /жилээр/	Шинэчлэн тогтоосон үнэ /төгрөг/		
1	2 Хаалгатай шкаф хүрэн	2015-12-19	ш	1	90,909.00	2	18,181.80		
2	Зурагтын суурь	2016-02-15	ш	2	54,364.00	3	16,309.20		
3	Баримт бичиг хадаглах шилэн тавиур	2015-03-24	ш	1	45,455.00	3	13,636.50		
4	Хүрэн жижиг ширээ	2015-03-24	ш	1	45,455.00	3	13,636.50		
5	Ширээ хүрэн	2015-03-31	ш	1	227,273.00	3	68,181.90		
6	Туузан конвейер 218	2006-12-19	ш	1	12,559,227.24	5	6,279,613.62		
7	Инвектор/усан сан/	2013-04-26	ш	1	5,000,000.00	3	1,500,000.00		
8	Датчик UFM	2011-12-31	ш	2	1,100,000.00	2	220,000.00		
9	Тэвштэй өргөгч кран, 95-87 ДАА	2004-05-10	ш	1	41,255,072.72	1	4,125,507.27		
10	Компьютер ком /дэлгэц 22, процессор EM2610/	2013-01-27	ш	1	1,199,818.00	2	239,963.60		
11	Компьютер ком /дэлгэц 19 процессор EM2610/	2013-01-27	ш	1	1,199,818.00	2	239,963.60		
Нийт дүн							62,777,391.96		12,734,993.99
							(жаран хоёр сая долоон зуун далан долоон мянга гурван зуун ерэн нэгэн төгрөг ерэн зургаан мөнгө)		(арван хоёр сая долоон зуун гучин дөрвөн мянга есөн зуун ерэн гурван төгрөг ерэн есөн мөнгө)